



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/286.

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны “Батцэцэн” ӨЭМТ-ийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн наймдугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо “Батцэцэн” ӨЭМТ-ийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,711,287.00 (найман сая долоон зуун арван нэгэн мянга хоёр зуун наян долоон) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо “Батцэцэн” өрхийн эрүүл мэндийн төв (С.Энхномин)-д зөвшөөрсүгэй.

2. Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 16 нэр төрлийн нийт 8,511,287.00 (найман сая таван зуун арван нэгэн мянга хоёр зуун наян долоон) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, 2 нэр төрлийн 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг устгалын акт үйлдэн устгахыг 19 дүгээр хороо “Батцэцэн” өрхийн эрүүл мэндийн төв (С.Энхномин)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500077

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 05 дүгээр сарын 05-ны өдрийн 100 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн "Батцэцэн" БГБХН өрхийн эрүүл мэндийн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын нэр	Мэргэжлийн санал	ҮХХХК-ын шинэчлэл
1.Машин тоног төхөөрөмж													
1	Анхны тусламжийн иж бүрдэл	13	ш	1	611,834	611,834.00	611,834.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
2	Вакцины гар цүнх	11	ш	3	114,148	342,444.00	342,444.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
3	Зөөврийн компьютер	5	ш	1	1,500,000	1,500,000.00	1,500,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
4	Компьютер	8	ш	1	800,000	800,000.00	800,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
5	Компьютер иж бүрэн	6	ш	1	1,500,000	1,500,000.00	1,500,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
6	Саарал хөргөгч	21	ш	1	499,103	499,103.00	499,103.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
7	Суурин даралтын аппарат	13	ш	1	850,000	850,000.00	850,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
8	Ургийн чангуур	10	ш	1	220,000	220,000.00	220,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
9	Утлагын аппарат	13	ш	1	190,250	190,250.00	190,250.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
10	Утлагын аппарат	15	ш	1	280,000	280,000.00	280,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
							6,793,631.00	6,793,631.00					
2.Тавилга эд хогшил													
1	Өнгөт принтер	10	ш	1	104,656	104,656.00	104,656.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
2	Өлгий вандан	7	ш	1	180,000	180,000.00	180,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
3	Номын шкаф	15	ш	1	290,000	290,000.00	290,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
4	Сандал түшлэгтэй	7	ш	10	65,000	650,000.00	650,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
5	Ханы шкаф	24	ш	1	438,000	438,000.00	438,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
6	Шал угаагч	7	ш	1	55,000	55,000.00	55,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах	татах
							1,717,656.00	1,717,656.00					
1	Программ	11	ш	1	90,000	90,000.00	90,000.00	-	ашиглагдахуу	актлах	устгах	устгах	устгах
2	Программ ня-бо	11	ш	1	110,000	110,000.00	110,000.00	-	ашиглагдахуу	актлах	устгах	устгах	устгах
							200,000.00	200,000.00					
							8,711,287.00	8,711,287.00					
Нийт дүн													
Үүнээс: Худалдан оорлуулах хөрөнгө													
Татан төвлөрүүлэх													
Устгах хөрөнгө													
Худалдсанаас олох орлого													
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/													